



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/350

Хэрлэн сум

Соёлын биет бус өвийн үзлэг судалгаа,
зохион байгуулах, ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.4, 16.1.5, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл урлагийн газрын даргын А/42 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээний нутаг дэвсгэрт соёлын биет бус өвийн үзлэг судалгааг 2022 оны 11 дүгээр сарын 01-ээс 2022 оны 11 дүгээр сарын 15-ыг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Соёлын биет бус өвийн үзлэг судалгааг нэгдсэн арга зүйгээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	Т.Зулбаатар	Соёл, урлагийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Л.Бүрэнтөгс	Соёл, урлагийн газрын Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Д.Баатарцогт	Соёл, урлагийн газрын Соёлын хэлтсийн дарга
	Э.Сайнзаяа	Музейн арга зүйч
	Г.Нарантунгалаг	Музейн бүртгэл мэдээллийн санч

3. Үзлэг судалгааны ажлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, нэгдсэн дүн, цаашид авах арга хэмжээний саналыг аймгийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг дарга (Т.Зулбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ